



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 18 өдөр

Дугаар 4/429

Чингис хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 15 дугаар хуралдааны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 15 дугаар хуралдааны 01 дүгээр тогтоолын 2, 3 дугаар хавсралтаар батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтаас сумдад эрх шилжүүлэх хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журмын дагуу шуурхай зохион байгуулж, гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангах арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар /Н.Үнэнбат/, барилга угсралт, их засварын ажлын захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Баярхүү/-т даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

201010540

09 Аймгийн Засаг даргын 2020 оны  
 дугаар сарын 18 өдрийн 1/129  
 дугаар захирамжийн хавсралт

Д/д	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нэр	Хугацаа		Төсөвт өртөг	2020 онд санхүүжих	Эрх шилжүүлсэн ТЭЗ
		Эхлэх	Дуусах			
1	Аврах бүлгийн байрны засвар /Жаргалтхаан/	2020	2020	19,000.0	19,000.0	Жаргалтхаан сумын Засаг дарга
2	Баянмөнх сумын цэвэр усны эх үүсвэрийн худаг	2020	2020	7,500.0	7,500.0	Баянмөнх сумын Засаг дарга
3	Баянмөнх сумын "Залуус төгөл"-ийн хашаажуулалт	2020	2020	16,500.0	16,500.0	Баянмөнх сумын Засаг дарга
4	Хёрхон голын бяраазны 2 талын гүүр барьж, зам засварлах	2020	2020	15,000.0	15,000.0	Дадал сумын Засаг дарга
5	Баян-Овоо сумын хогийн цэгийн нэмэлт хашаажуулалт	2020	2020	20,000.0	20,000.0	Баян-Овоо сумын Засаг дарга
6	Өмнөдэлгэр сумын Хэнтий баг, Талын булаг багт гүн өрмийн худаг гаргах	2020	2020	30,000.0	30,000.0	Өмнөдэлгэр сумын Засаг дарга
7	Дизель генератор, дулаан хязгаарлагч /Дархан сум/	2020	2020	14,400.0	14,400.0	Дархан сумын Засаг дарга
8	Фитнесийн тоног төхөөрөмж /Цэнхэрмандал сум/	2020	2020	9,500.0	9,500.0	Цэнхэрмандал сумын Засаг дарга
9	ЗДТГазрын гадна тохижилт /Цэнхэрмандал сум/	2020	2020	7,000.0	7,000.0	Цэнхэрмандал сумын Засаг дарга
10	Ундны усны худаг засварлаж, ухаалаг систем суурилуулах /Дэлгэрхаан сум/	2020	2020	10,000.0	10,000.0	Дэлгэрхаан сумын Засаг дарга
11	Хот тохижилтын тоног төхөөрөмж /Бор-Өндөр сум/	2020	2020	30,000.0	30,000.0	Бор-Өндөр сумын Засаг дарга
12	Галшар сумын Цэцэрлэгийн шугам сүлжээний засвар	2020	2020	40,400.0	40,400.0	Галшар сумын Засаг дарга
13	Бэрх тосгоны гэр хорооллын худгийг засварлаж, ухаалаг систем суурилуулах	2020	2020	16,000.0	16,000.0	Бэрх тосгоны Захирагч
14	Бэрх тосгоны доторх авто зам болон явган хүний замын засвар	2020	2020	9,000.0	9,000.0	Бэрх тосгоны Захирагч
15	Халуун усны тоног төхөөрөмж /Галшар сумын Буянтбулаг/	2020	2020	17,000.0	17,000.0	Галшар сумын Засаг дарга
	Нийт дүн			261,300.0	261,300.0	